

СОЁМБО МЭДЭЭ

ҮЙЛ ЯВДАЛ

Х.Баттулга: ХҮНД ЦАГИЙН БАЙДАЛД УДААН ХУГАЦААГААР ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭНЭ ГЭДЭГ ЦЭРЭГ ХҮНЭЭС Л ГАРАХ ЧАДВАР ЮМ

Агуу их Эх орны дайны ялалтын баярын өдөр Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулагдсан Зэвсэгт хүчний түүхт 100 жилийн ойн баярын хурал, шагнал гардуулах арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр болон ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг нарын хэлсэн үгийг бүрэн эхээр нь хүргэж байна.



Монгол Улсад Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулагдсаны 110, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн баярын арга хэмжээний нэг хэсэг нь БНӨСУ болон ИБНАУ-д

энхийг сахиулах үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн цэргийн багуудад баяр хүргэж, Төрийн одон, медаль болон батлан хамгаалах салбарын шагнал гардуулах ёслол байлаа.

Энхийг сахиулагчдад хандаж Монгол Улсын

Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга баяр хүргэж хэлсэн үгэндээ “Туурга тусгаар Монгол Улсынхаа нэр хүндийг дэлхий дахинд дуурсгаж, Монгол хүн, Монгол цэрэг гэж ямар итгэлтэй, ямар чадварлаг хүмүүс байдгийг үйл ажиллагаагаараа нотлон харуулж, зэвсэгт мөргөлдөөн, иргэний дайны золиос болсон ард түмэнд энх тайван, аюулгүй байдлыг авчрах их үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулж, төр засаг, цэргийн дээд удирдлагаас даалгасан өндөр хариуцлагатай үүргийг нэр төртэй биелүүлсэн Та бүхэндээ чин сэтгэлийн халуун баяр хүргэж, талархал дэвшүүлье. Дэлхийн улс орнууд энхийг эрхэмлэн, энх тайвныг бэхжүүлэх талаар хүчин чармайлт гаргаж, аливаа маргаантай асуудлыг эвийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэж, үүгээрээ тодорхой үр дүнд хүрч байгаа ч бүс нутаг, улс орон, овог аймаг, шашин хоорондын сөргөлдөөн, үймээн самуун бүрмөсөн арилахгүй байгаа нь даяаршил улам бүр гүнзгийрч байгаа дэлхий ертөнцөд хэн бүхний сэтгэлийг түгшээсэн ээдрээтэй асуудал хэвээр байна.

Ийм ээдрээтэй нөхцөл байдалд Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн орны хувьд дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх үйлсэд тодорхой үүрэг, хариуцлага хүлээж өөрийн хувь нэмрээ Та бүхнээр дамжуулан зохих ёсоор оруулсаар байгаа юм.

Монгол Улсын хувьд даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх асуудалд өөрийн байр суурийг хадгалж, аливаа зөрчилтэй асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх талаар санаачилгатай ажиллаж, тодорхой үүрэг, хариуцлага хүлээн, энхийн үйл хэрэгт бодитоор дэмжлэг үзүүлэн оролцож байна.

Энхийг сахиулах ажиллагаа бол Монгол Улсын гадаад бодлогын тулгуур зарчмуудын нэг болсон энхийг эрхэмлэсэн олон тулгуурт нээлттэй гадаад бодлогын хамгийн идэвхтэй, хамгийн бодитой, хамгийн үр дүнтэй үйл ажиллагаа болсон төдийгүй манай улс хүн төрөлхтний амар амгалан амьдрал, дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үйл хэрэгт эрс тууштай зогсож байгаагийн тод томруун нотолгоо болж

байна. Энхийг эрхэмлэгч манай орон даян дэлхийд энх тайван, амар амгаланг тогтоох хүн төрөлхтний шударга, ариун үйл хэрэгт оруулж буй хувь нэмэр, хүчин чармайлтаа цаашид ч улам бүр өргөжүүлэх болно. Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаа болон Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдаж буй “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаа нь тухайн бүс нутагт тогтвортой байдлыг бий болгоход онцгой ач холбогдолтой бөгөөд манай энхийг сахиулагчид энэхүү ажиллагаанд голлох үүрэгтэй оролцож, бэлэн байдал, үүрэг гүйцэтгэлт, сахилга зохион байгуулалтаараа бусад орнуудын ижил түвшний цэргийн багуудад үлгэр дууриалал болж НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгч болон цэргийн хүчний командлалаас удаа дараа сайшаагдсан тухай мэдээг хүлээн авахад ямагт таатай байдгийг зориуд онцлон тэмдэглэе. Цаг агаарын эрс тэс нөхцөл, эрүүл мэндийн эрсдэлтэй орчин, гэнэт өөрчлөгдөх хүнд цагийн байдалд удаан хугацаагаар үүрэг гүйцэтгэнэ гэдэг хүн болгоны хийж чадах хялбар ажил биш юм. Энэ бол гагцхүү цэрэг хүний цог жавхаа, золбоо хийморь, нугаршгүй хатан зориг, мятаршгүй хичээл зүтгэлээр л биеллээ олох амжилт бөгөөд манай энхийг сахиулагчид бүтээж чадсаар байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг хүлээсэн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын бие бүрэлдэхүүний НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаанд оруулж буй хувь нэмэр, хичээл зүтгэл, амжилт бүтээлийг баярын энэ өдөр бахархан тэмдэглэж байна” хэмээгээд эх орон, төр, ард түмнийхээ өмнө хүлээсэн нэр хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргээ амжилттай гүйцэтгэсэн болон гүйцэтгэж буй энхийг сахиулагчдын цаашдын ажил хөдөлмөрт өндөр амжилт хүссэн юм.

Үүний дараа Монгол Улсад Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулагдсаны 110, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан нэгдсэн тооллого явуулж, ёслолын буудлага хийж, цэргийн ёслолын жагсаалаар алхлаа.

ЭХ ОРОН, АРД ТҮМНЭЭ БАТЛАН ХАМГААЛАХ ҮҮРГЭЭ МОНГОЛ ЦЭРЭГ ГҮЙВАЛТГҮЙ БИЕЛҮҮЛСЭЭР ИРСНИЙГ ТҮҮХ ГЭРЧИЛНЭ

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаа,

Энд хүрэлцэн ирсэн эрхэм зочид, Элчин сайд нараа,

Зэвсэгт хүчинд алба хааж буй генерал, офицер, ахлагч, ажилтан, албан хаагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид аа,

Даян дэлхийн энх тайвны төлөө Монгол цэргийн суу алдрыг дуурсган дэлхийн халуун цэгүүдэд үүргээ нэр төртэй гүйцэтгэж яваа манай эрэлхэг энхийг сахиулагчид аа,

Та бүхэндээ “Монгол цэргийн өдөр”, Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Анхны төрт улс Хүннү гүрний үеэс улбаатай төр улсаа төвхнүүлэх, түмэн олноо хамгаалах, төрийн бодлогын тулгуур Монгол цэрэг их эзэн Чингис хааны Хар сүлдний ивээл дор дэлхий дахинд энх тайван, амар амгаланг тогтоохын төлөө тэмцэж явсан гайхамшигт баялаг түүхтэй билээ.

Монгол үндэстэн эв эеэ нэгтгэн мандан бадарч, харь улсын бодлого, хаад, ноёдын урвалтаас үүдэн сулран доройтох түүхэн жам ёсны тавиланг тойроогүй дайран гарсан. Энэ л түүхийн олон нугачаан дунд улс гүрэн, эх орон, ард түмнээ батлан хамгаалах үүргээ “Монгол цэрэг” гуйвалтгүй биелүүлсээр ирсэн түүх гэрчилнэ.

Тэртээх 1921 онд Ардын журамт цэргийг эмхлэн байгуулж, цэрэг, зэвсгийн хүчээр улс үндэстнээ харийн дарлалаас чөлөөлж, туурга тусгаар улсаа сэргээн мандуулах Үндэсний ардчилсан хувьсгалыг эхлүүлснээр зуун зууны түүхийн хуудсыг өртөөлсөн “Монгол цэрэг”-ийн шинэ үе, орчин үеийн Зэвсэгт хүчний түүх эхэлсэн.

Шинэ тулгар Ардын засгийн зүгээс Ардын журамт цэргийг бэхжүүлэх бодлогын хүрээнд морьт цэргийн хороо, дивиз, корпустай болж түүний бүрэлдэхүүнд хуягт танкийн, их бууны, нисэхийн, холбооны цэргийн ангиудыг шинээр байгуулж, ардын хувьсгалт улаан цэргүүдийг болон олон ардуудыг цэргийн эрдэмд боловсруулах, байлдааны шинэ зэвсэг техник, мэргэшсэн хүн хүчээр хангах, байлдааны болон улс төрийн бэлтгэлийг дээшлүүлэх, цэргийн сахилгыг бэхжүүлэх талаар олон арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлсэн байдаг.

“Монгол цэрэг” Монгол Улсынхаа газар нутаг, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд халдсан харийн дайсны эсрэг 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайнд Зөвлөлтийн дайчидтай мөр зэрэгцэн тулалдаж, эх орон, ард түмэн, тусгаар



тогтнолоо хамгаалах ариун үүргээ нэр төртэй биелүүлэхийн хамт Зүүн хойд Хятадыг чөлөөлөх цус асгаруулсан ширүүн тулаанд оролцож, Дэлхийн дайны ялалтад хувь нэмрээ оруулсан түүхэн гавьяаг байгуулж явсан.

1960-аад оноос дэлхийн болон бүс нутгийн цэрэг-улс төрийн байдал, цэргийн хэрэгт гарсан хувьсал, зэвсэгт тэмцлийг явуулах онол, практикийн өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Ардын Хувьсгалт Цэргийг мотобуудлагын цэрэг болгон шинэчлэн зохион байгуулж, Зөвлөлт Холбоот Улсын цэргийн академи, их, дээд сургууль төгссөн чадварлаг даргалах бүрэлдэхүүнтэй, орчин үеийн байлдааны зэвсэг, цэргийн техникээр хангагдсан, үүрэг гүйцэтгэх чадавхаараа хөрш орнуудын түвшинд ойртсон Монголын Ардын Арми болон өргөжин хөгжиж ирсэн түүхэн замналтай.

Эрхэм нөхөд өө. 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг мөн” болохыг тунхаглаж, Зэвсэгт

хүчинтэй байна” хэмээн тодорхойлж, энэ л цаг үеэс тайван цагт улс орныхоо батлан хамгаалах хэрэгцээ шаардлага, эдийн засгийн боломжид нийцсэн цомхон, чадварлаг Зэвсэгт хүчинтэй байна гэж тодорхойлсны дагуу нэн шинэ үеийн Зэвсэгт хүчнийг зохион байгуулж, төр, засгийн зүгээс Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх чиглэлээр шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирлээ.

Өвөг дээдсийнхээ мянга мянган жилийн баатарлаг түүх, дайчин уламжлалыг өнөө цаг үед нэр төртэйгээр залгамжилж яваа “Монгол цэрэг”, Монгол Улсын Зэвсэгт хүчин улс төр, дипломатын аргаар аюулгүй байдлаа хангах, энхийг эрхэмлэсэн олон тулгуурт нээлттэй бодлогыг хэрэгжүүлэх гадаад бодлогын үндсэн зарчмыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмрээ оруулж, Энхийг дэмжих ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа явдал нь дэлхий дахины энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг сахин хамгаалах үйл хэрэгт манай улс эрс тууштай зогсож байгаагийн тод томруун нотолгоо болж байгаа юм.

Манай цэргийн алба хаагчид 2002 оноос энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлснээс

хойш өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор 19000 гаруй офицер, ахлагч үүрэг гүйцэтгэсэн бөгөөд өдгөө Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулагчид дэлхийн хамтын нийгэмлэгээс “Гуйвшгүй, Төвшин, Чадвартай” гэсэн үнэлгээ аваад байгааг бахдан дуулгая.

Монгол дайчид маань дэлхийд нэрээ гаргахаас гадна Монгол Улсынхаа бүтээн байгуулалтад бодитой хувь нэмрээ оруулсаар байна. Монгол Улсын Зэвсэгт хүчин нь Үндэсний бүтээн байгуулагч компаниудтай хамтран улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтад оролцож, ард түмний бүтээлч оюун санааны бахархал, эх оронч хүмүүжлийг батжуулахад тэргүүлэх үүрэгтэй оролцож байна. Төмөр замын бүтээн байгуулалт, газрын тос боловсруулах үйлдвэрийн хүнд даацын авто зам, “Жишиг сум” төсөл гээд олон ажлуудад Зэвсэгт хүчин манлайлан оролцож богино хугацаанд, чанарын өндөр түвшинд гүйцэтгэж байна.

Дэлхийн болон бүс нутгийн улс төр, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны эрс хурдацтай өөрчлөлтийн энэ үед улс орныхоо батлан хамгаалах хүч чадлыг нэмэгдүүлэх, Зэвсэгт хүчнээ хөгжүүлж, бэхжүүлэх үүднээс “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод аюулгүй байдлын орчны өөрчлөлт, шинжлэх ухаан, техник технологийн ололт амжилт, цэргийн урлагийн хөгжил дэвшилд нийцүүлэн батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийхээ хөгжлийн “Алсын хараа”-г шинээр тодорхойллоо.

Энэ үндсэн дээр улс орны батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэх, чадавхыг бэхжүүлэх гол зорилтын хүрээнд цэргийн мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан орчин үеийн зэвсэглэл, цэргийн техник бүхий чадварлаг Зэвсэгт хүчнийг бэхжүүлэхийг эрхэмлэж байна.

“Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны яруу алдарт 100 жилийн ойг тохиолдуулан эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө цогтой тэмцэж ирсэн үе үеийн ахмад дайчид, эх орноо батлан хамгаалах хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргээ нэр төртэйгээр биелүүлж байгаа цэрэг дайчдаа баярын мэндчилгээг дахин дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, ажил хөдөлмөрийн өндөр амжилт, амьдралын хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

БҮХ ЦЭРГИЙН ИХ ХАР СҮЛД ИВЭЭЖ, МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН ҮЕИЙН ҮЕД МАНДАН БАДРАХ БОЛТУГАЙ!

Хошууч генерал Д.Ганзориг: ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАЙГУУЛСАН ГАВЪЯА ҮНЭЛЖ БАРИШГҮЙ БӨГӨӨД ХЭМЖЭЭЛШГҮЙ

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч аа!
Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд аа!

Монгол Улсынхаа эрх чөлөө, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг сахин хамгаалах үйл хэрэгт хөдөлмөр зүтгэл, залуу насаа зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид аа!

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч, ажилтан албан хаагч, хилийн чанадад үүргээ нэр төртэй гүйцэтгэж буй энхийг сахиулагчид аа!

Эрхэмсэг хатагтай, ноёд оо!
Бидний өвөг дээдсийн мянга мянган жилийн түүхийг монгол цэрэг зуун зуунаар өртөөлж ирсэн билээ. 1921 оны 3 дугаар сард ялалтын тугаа мандуулсан Монгол Ардын журамт цэргээс эхлэлтэй орчин цагийн Зэвсэгт хүчин өнөөдөр 100 жилийнхээ ойгоо тэмдэглэж байна.

Монголчууд бид төрт улс, төрт ёсыг үүсгэн байгуулсан цагаас эхлэн эх нутаг, эх орныхоо туурга тусгаар, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын төлөө баатарлагаар тэмцэж ирсэн цэрэг, арми, Зэвсэгт хүчний баялаг түүхтэй.

Энэ их баялаг түүхийн нэгэн зууны ойн гэрч болж буй эрхэм хүндэт Та бүхэнд Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин байгуулагдаж хөгжсөн 100 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Өнгөрсөн XX зуун бол монголчуудын хувьд үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулах, дэлхий дахинд өөрийн гэсэн нэр хүнд, байр суурь, орон зайг олж авах, бэйжүүлэхийн төлөөх их тэмцлийн зуун байлаа.

Монголын ард түмний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын төлөөх тэмцэл, хүчин чармайлтын үр дүнд 1921 онд Ардын зэвсэгт хувьсгал ялж, манай улс тусгаар тогтнол, Монголын ард түмэн эрх чөлөөгөө эдлэх үүд хаалгыг нээсэн түүхтэй.

Ардын хувьсгалын ялалтад Ардын журамт цэрэг түргүүлж үүрэгтэйгээр оролцож, ард түмний итгэл үнэмшил, хүсэл зоригийг хурцалж, харийн дайсныг Монгол орноос үлдэн хөөж, шинэ үеийн түүхийг бичилсэн нь Монголын Зэвсэгт хүчний түүхтэй салшгүй холбоотой бөгөөд Монголын ард түмний өмнө байгуулсан гавьяат үйлсээрээ түүхэнд мөнхөрсөн билээ.

XX зууны эхэнд "орших, эс орших"-ын заагт байсан Монгол Улс өнөөдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүн болж, ардчиллын үнэт зүйлийг сахин хамгаалах, дэлхий дахинд энхийг сахиулж байгаа хичээл зүтгэл, эдийн засгийн нөөц боломжоор олон улсын анхаарлын төвд байгаа бөгөөд Монгол Улсын нэгэн зууны хөгжил дэвшилд Зэвсэгт хүчин асар их үүрэг гүйцэтгэсэн.

Монгол Улсын "Үндсэн хууль"-иар төр засаг, ард түмний өмнө хүлээсэн үүргээ Зэвсэгт хүчин нэр төртэй биелүүлсээр ирсэн. Монгол Ардын Хувьсгалт Цэрэг, Зөвлөлтийн Улаан армитай хамт 1939 оны Халхын голын байлдаанд ялалт байгуулж, эх орныхоо тусгаар тогтнолыг хамгаалж, дэлхийн тэргүүлэх улс гүрнүүдэд Монгол Улсын гал голомт мандан буйг дахин зарлан тунхагласан түүхэн ач холбогдолтой үйл явдал болсон.

Хүн төрөлхтөн өөр хоорондоо олон мянган удаагийн дайн, байлдаан хийснээс хамгийн аймшигтай нь Дэлхийн II дайн байсан юм. Энэ дайнд дэлхийн 61 улс, хүн амын 80 хувь нь оролцсон бөгөөд дайны хар сүүдэр манай улсыг ч дайран өнгөрснийг бид мартаагүй, мартах ч учиргүй.

Дэлхийн II дайны төгсгөлд Алс Дорнодод явуулсан цэргийн операцдад Монгол Ардын Хувьсгалт Цэрэг оролцсон үйл явдал нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнолыг бататгахын төлөө, дэлхийн тэргүүлэх улс гүрнүүдээр олон улсын хэмжээнд тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө цус асаруулсан дайн байлаа.

Энэ ялдамд өнөөдөр тэмдэглэж буй Аугаа их Эх орны дайны ялалтын 76 жилийн ойн баярын мэндийг Та бүхэндээ хүргэе.

Эдгээр дайн болон бусад байлдаанд оролцсон Монгол Ардын Хувьсгалт Цэргийн бие бүрэлдэхүүний асаруулсан цус, өргөсөн амь гагцхүү эх орныхоо төлөө, түүний тусгаар тогтнол, Монголын ард түмний эрх чөлөөний төлөө байсныг онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Энэ бүх ялалт, амжилтаар Монгол Улсын Зэвсэгт хүчин, түүний эрэлхэг дайчид Монголын төр засаг, ард түмний хүндэтгэлийг зүй ёсоор хүлээж, байлдаан, зэвсэгт тэмцэлд амь насаа үл хайрлан эрэлхгээр оролцсон цэргийн дарга, байлдагчид дотроос Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар хэмээх алдар цолыг 40 гаруй хүн хүртсэн нь яах аргагүй өнөөгийн бидний бахархал мөн.

1939 оны Халхын голын байлдаан,



1945 оны Чөлөөлөх дайн, Баруун хилийн тулгаралтад оролцсон эрх орноо баатарлагаар хамгаалсан ахмад дайчид, цэргийн хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, ар тал, хангалтыг зохион байгуулах амаргүй үүргийг биелүүлсэн далд фронтын дайчид, тэдний үр хүүхэд, ач зээ нарт яруу алдарт, дайчин замналт Зэвсэгт хүчнийхээ 100 жилийн ойн баярын мэндийг хүргэж, нийт бие бүрэлдэхүүнийхээ өмнөөс эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн өрөөе.

Зэвсэгт хүчний хөгжил бүс нутгийн аюулгүй байдлын орчноос гадна улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилтэй нягт уялдаатай явж ирсэн. Монгол Улсын Зэвсэгт хүчин Дэлхийн II дайны дараа тайван цагийн бүтээн байгуулалтад шилжин, зохион байгуулалтын хувьд хураангуй болж, улс ардын аж ахуй, бүтээн байгуулалтад бие бүрэлдэхүүн, техник хэрэгслээ шилжүүлснээр 1950-аад оны сүүлчээр хүн амын 10 орчим хувь Зэвсэгт хүчинд алба хааж байсныг 0.2 хувь болгон бууруулсан юм.

Зэвсэгт хүчин эх орноо батлан хамгаалах үндсэн үүргийнхээ зэрэгцээ ард олныг бичиг үсэгт сургаж, ардын эрүүлийг хамгаалах, орчин үеийн соёл боловсрол, шинжлэх ухаан, урлаг, анагаах ухааны ололтыг нэвтрүүлэх, аж үйлдвэр, улс ардын аж ахуйг хөгжүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан нь бахархууштай үйл мөн.

Бүтээн байгуулалтын он жилүүдэд Монголын Ардын Арми эх орныхоо бүтээн байгуулалт, соёлын хувьсгалд үнэтэй хувь нэмэр оруулсныг Монголын төр засаг, ард түмэн өндөрөө үнэлсээр ирснийг баярын энэ өдөр онцлон тэмдэглэх учиртай.

Зэвсэгт хүчний эгнээнээс улсын болон хөдөлмөрийн баатрууд, Монгол төрийн жолоодогч, төр, нийгмийн нэрт зүтгэлтнүүд, эрдэмтэн мэргэд, дипломат, сурган хүмүүжүүлэгч, зохион бүтээгчид, сансрын нисэгч, тив дэлхийд алдар нэрээ дуурсгасан урлаг, спортын гавьяатууд төрөн гарч улс орныхоо нэр хүндийг тив дэлхийд дархлан мандуулж байсан бөгөөд өнөөдөр ч нэр алдраа мандуулж байгаа нь бахархам түүх мөн.

Бүтээн байгуулалтад оролцсон Барилгын цэргийн анги, салбарууд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Дорнод бүс нутагт аж үйлдвэрийн их бүрэн парк-районыг барьж байгуулснаас гадна цэрэг армийнхаа хөгжил, батлан хамгаалах хүч чадлын үндэс болсон материаллаг баазыг өргөтгөхөд нэр их ажил хийжээ.

Дэлхийд ноёрхож байсан хоёр туйлт системийн сөргөлдөөн цэргийн байгуулалтыг шинэчлэхийг шаардаж байсан 1956-1964 онд Монгол Ардын Хувьсгалт цэргийг Морьт механикжуулсан цэргээс Мотобуудлагын цэрэг, 1965-1979 онд Монголын Ардын Армийг орчин үеийн төрөл, мэргэжлийн тусгай бригад, хороо, батальон, ротын зохион байгуулалт бүхий мотобуудлагын цэрэг болгон өргөтгөж, 1980-1990 онд Монголын Ардын Арми эрчимтэй шинэчлэгдэж ерөнхий цэргийн арми, армийн корпус, мотобуудлагын дивиз, тусгай хорооны зохион байгуулалтад орж, төрөл, тусгай мэргэжлийн бие даасан цэрэгтэй болсон. Ингэснээр тухайн цаг үедээ монгол цэргийн шинэ үеийн түүхэнд байгаагүй бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, техник, байлдах чадвар бүхий орчин үеийн Зэвсэгт хүчнийг байгуулсан

юм. Дайны дараах он жилүүдэд цэргийн урлагийг хээрийн сургууль, команд-штабын хээрийн сургуулиар хөгжүүлж, Зөвлөлтийн болон бусад орны цэргийн урлаг дахь шинэ чиг хандлагыг цэргийн сургалт бэлтгэлд нэвтрүүлэх, цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлж байв. Тухайлбал "Хэрлэн-73", "Говь-77", "Найрамдал-79" зэрэг томоохон хэмжээний хамтарсан болон бие даасан хээрийн сургуулийг зохион байгуулсан нь Зэвсэгт хүчнийг дайны байдалд шилжүүлэх, нэгтгэл, ангийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах, бүлэг байдлын зэрэгт шилжүүлэх, төрөл, тусгай мэргэжлийн цэргийг хэрэглэх урлагт үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

Монгол хүн 1981 оны 3 дугаар сарын 22-ны өдөр анх удаа сансарт ниссний 40 жилийн ой саяхан тохиосон. Сансарт эх орныхоо нөр алдрыг дуурсгах ховорхон завшаан мөн л Зэвсэгт хүчний эгнээнд алба хааж байсан цэрэг хүнд тохиосон нь бидний бахархлын нэг мөн билээ.

1980-аад оны сүүлчээр дэлхий дахин болон бүс нутаг дахь цэрэг-улс төрийн тааламжтай нөхцөл байдлаас үүдэн Зэвсэгт хүчний тоо хэмжээг хорогдуулах замаар улс орны эдийн засгийг дэмжих зорилтын хүрээнд 1988 оноос ерөнхий цэргийн армийн бүтцийг халж, армийн штаб, түүний харьяаны хангалт, үйлчилгээний ангиудыг татан буулгаж, 1989 оноос Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг 13000 цэргийн алба хаагчаар хорогдуулж, мотобуудлагын дивизүүдийн зэвсэглэл, цэргийн техникийг удаан хугацааны хадгалалтад шилжүүлсэн. Ийнхүү Зэвсэгт хүчнээ хураангуй бүтэц, зохион байгуулалттай болгож, цэргийн сургалт бэлтгэл, бодлого, төлөвлөгөөг өөрчилж, улс орноо бие дааж батлан хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн түүхтэй.

Монголын Ардын Армийг өргөтгөн зохион байгуулах үед алба хааж байсан ахмадууд, бэлтгэлд болон чөлөөнд байгаа генерал, офицер, ахлагч, албан хаагчид, цэргийн жинхэнэ алба хаасан байлдагч, түрүүч Та бүхэнд Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье!

Эрхэм хүндэт зочид, генерал, офицер, ахлагч, гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч, ажилтан, алба хаагчид аа!

Ардчилсан хувьсгалын он жилүүдэд Монгол Улсын Зэвсэгт хүчин улс орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах, бататган бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, батлан хамгаалах хэрэгцээ, шаардлага, эдийн засгийн боломжид нийцсэн цэргийн байгуулалтыг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулсаар ирсэн.

Монгол Улс 1990-ээд оноос ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжиж, шинэ Үндсэн хуульдаа "өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчинтэй байх"-ыг хуульчлан баталгаажуулж, Зэвсэгт хүчин иргэний хяналтад байх ардчилсан нийгмийн зарчим, Зэвсэгт хүчний үнэт зүйлийг хадгалах, улс орны эдийн засгийн чадавх, бодит боломжид нийцсэн "мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бүрдүүлж хөгжүүлэх" бодлогыг үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлсээр байна.

Өнөөгийн тайван цагт Зэвсэгт хүчин оршин байхын учир нь Монгол

Улсын аюулгүй байдлын гадаад, дотоод орчныг хангахад дэмжлэг үзүүлэх, эх орноо батлан хамгаалах, орчин цагийн дайн, цэргийн урлагт гарч буй онол-практикийн өөрчлөлтийг судлан шинжилж, түүнд Зэвсэгт хүчний байгуулалтыг нийцүүлэх, цэргийн алба хаагчдаа сургаж бэлтгэх, байлдааны байнгын бэлэн байдлыг хангах явдал юм.

Зэвсэгт хүчний эрх зүйн орчны шинэчлэл, бүтэц, зохион байгуулалтыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлэх арга хэмжээг үе үеийн төр засгийн удирдлага, үе үеийн Батлан хамгаалахын яам, Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүн хэрэгжүүлж ирсэн гэдгийг тэмдэглэхэд таатай байна.

Монгол Улсын төрөөс баримтлах батлан хамгаалах бодлогыг Улсын Их хурлаар 2016 онд, цэргийн номлолыг хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаар 2018 онд батлуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Өдгөө бид Монгол Улсын Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг аюулгүй байдлын орчин, дэлхийн хэмжээнд гарч буй цэргийн хэргийн хөгжлийн жишигт нийцүүлэн улам бүр боловсронгуй болгон хөгжүүлж байна.

Зэвсэгт хүчин нь Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг, Тусгай хүчний цэрэг, Кибер аюулгүй байдлын цэрэг, Барилга-инженерийн цэргээс бүрдсэн, улс орныг цэргийн хүч хэрэгслээр батлан хамгаалах чиг үүрэгтэй төрийн цэргийн байгууллага болж хөгжин, эх орныхоо агаарын хилийн халдашгүй дархан байдлыг сахин хамгаалж, гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллийн эсрэг зэвсэгт тэмцэл явуулах бэлтгэлээ амжилттай хангахын зэрэгцээ энхийг дэмжих ажиллагаанд амжилттай оролцсон улс орныхоо нэр хүндийг олон улсын тавцанд хүндэтгэлтэйгээр өргөж яваа билээ.

Монгол цэргийн мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар, авхаалж самбаа, тэсвэр хатуулга, сахилга зохион байгуулалт өсөн нэмэгдэж байгаа бөгөөд монгол цэргийг олон улсын түвшинд "Дэлхийн цэрэг мөн" хэмээн үнэлж байна. Монгол Улсын Зэвсэгт хүчин анх 2002 онд Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад явагдаж буй НҮБ-ын ЭСАН-д хоёр цэргийн алба хаагчийг илгээснээр Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны түүх эхэлсэн юм. 2002 оноос хойш Зэвсэгт хүчний цэнхэр дуулагчид дэлхийн халуун цэгт энхийг эрхэмлээд улс орнуудын цэргийн алба хаагчидтай мөр зэрэгцэн 10 гаруй энхийг дэмжих ажиллагаанд оролцож, давхардсан тоогоор нийтдээ 19 мянга орчим цэргийн алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн байгааг онцлон тэмдэглэж байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагад цэрэг хандивлагч 123 улсаас өнөөдөр үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчийнхаа тоогоор Монгол Улс эхний 24-т багтаж байгааг дурдахад таатай байна.

Цэргийн багийн бүрэлдэхүүнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчид ч багтаж байгааг онцлохын зэрэгцээ өнгөрсөн хугацаанд дайн дэлхийн энх амгалангийн үйлсэд бодит хувь нэмрээ оруулж, энхийг дэмжих ажиллагаанд үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн нийт энхийг сахиулагчид болон ажиллагааны газар оронд үүргээ амжилттай гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн бие бүрэлдэхүүн, цэргийн алба хаагчдад баярын мэнд хүргэж ажил албанд нь арвин их амжилт, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн өрөөе.

Энэ цаг мөчид дэлхийн халуун цэг болох Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс, Исламын Бүгд Найрамдах Афганистан Улс, Бүгд Найрамдах Судан Улсын Абией муж, Йемен Улс, Баруун Сахар, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад манай 1100 гаруй цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй гүйцэтгэж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин даян дэлхийн энх тайвны төлөөх үйл хэрэг, бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагаанд хөрш орон, гуравдагч хөршүүд болон бусад улстай хамтран энхийг дэмжих ажиллагааны чадавхыг бэхжүүлэх сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулах замаар хувь нэмэр оруулж байна. Үүний тод жишээ бол Даян дэлхийн энх тайвны төлөөх санаачилгын хүрээнд жил бүр зохион байгуулдаг "Хааны эрэлд" олон улсын сургалт, дадлага, хамтарсан "Сэлэнгэ", "Анчин бүргэд", "Баланс мэйжик", "Нүүдэлчин заан", "Нүүдэлчин дайчид", "Зам", "Шийдэмгий шийдвэр" зэрэг хоёр талын цэргийн сургалт, дадлага юм.

Монгол Улс үйл олноор хөнөөх зэвсгийг үл дэлгэрүүлэх энх тайванч бодлогыг тууштай дэмжиж ирсэн бөгөөд олон улсын химийн зэвсэглэлийг устгах байгууллагад Зэвсэгт хүчний алба хаагчид үнэтэй хувь нэмэр оруулж, тус байгууллага нь Нобелийн шагнал хүртсэн яруу түүх бий. Ийнхүү Монгол Улсын Зэвсэгт хүчин дэлхийд танигдаж, алдар нэрээ мандуулж

байгаа нь монголчуудын бас нэг бахархал билээ. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж, хамтарсан сургалт дадлагад оролцсоноор энхийг дэмжих чадавхыг нэмэгдүүлэхээс гадна улс эх орны аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсаа дэлхий дахинд сурталчлан таниулах, улс төр, эдийн засаг, гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэхэд онцгой ач холбогдолтойг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Анхлан Зөвлөлт Холбоот Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулсан цэргийн харилцаа эдүгээ ихэд өргөжин, дэлхийн 37 оронтой цэргийн харилцаа тогтоож, тэдгээрээс 15 улстай цэргийн хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлж, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, ХБНГУ, Их Британи болон Ирландын Вант Улс, Бельгийн Вант Улс, Канад, Бүгд Найрамдах Турк Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Франц, Катар Улстай хамтарсан сургалт дадлага явуулж, жилд давхардсан тоогоор гадаадын 1500, Зэвсэгт хүчний 2000 цэргийн алба хаагчийн мэдлэг, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлж байгаагийн зэрэгцээ харилцан туршлага солилцох, хамтын ажиллагаа үүний дотор цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

Зэвсэгт хүчин улс орныхоо стратегийн бүтээн байгуулалтад идэвх зүтгэл, зохион байгуулалттайгаар оролцож байгааг дурдахад таатай байна. Сүүлийн жилүүдэд улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлж Зэвсэгт хүчний Барилга, инженерийн цэрэг эх орныхоо бүтээн байгуулалт, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж эхэлсэн. Үүний нэг жишээ бол Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дахь газрын тос боловсруулах үйлдвэрийн 17.5 км урттай хүнд даацын авто зам, Дорнод аймгийн Халхгол суманд хэрэгжсэн "Шинэ сум" Төслийг богино хугацаанд гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж, Монгол Улсын аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудтай хамтран, тэдгээрийг манлайлан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын ажлыг амжилттай гүйцэтгэж дуусгавар болох шатандаа ороод явж байна.

Стратегийн ач холбогдол бүхий хүнд даацын хатуу хучилттай зам, төмөр замыг Зэвсэгт хүчин, үндэстний аж ахуйн нэгжүүдийн хамтын оролцоогоор бүтээн байгуулсан нь монголчууд өөрийн хүчээр томоохон хэмжээний бүтээн байгуулалтыг гүйцэтгэж чадахыг нотлон харуулж, "Бид чадна" гэсэн итгэл үнэмшлийг бий болгосон гэж хэлэхэд буруудгахгүй болов уу.

Эрхэм нөхөд оо!

Монгол Улсын Зэвсэгт хүчний хөгжлийн нэгэн зууны намтар бол тэмцэл, хөгжлийн их түүх бөгөөд улс, үндэсний тусгаар тогтнолыг сэргээн мандуулах, эх орноо батлан хамгаалахын төлөөх тэмцэл, төр, засгийн бодлого, стратегийн зорилтыг хэрэгжүүлэхийн төлөөх хичээл зүтгэл, Монголын ард түмний бахархал, хүндэтгэлийг хүлээсэн түүх мөн билээ.

Монгол Улсын Зэвсэгт хүчин ард түмнийхээ эрх чөлөө, хүсэл тэмүүлэл, итгэл үнэмшлийн илэрхийлэл болж байгаагийн сацуу, иргэний аюулгүй байдал, улс үндэстний язгуур ашиг сонирхлыг батлан хамгаалагчийн хувьд төр засгийнхаа бодлогыг нэр төртэй хэрэгжүүлж, хөгжил дэвшилд тэмүүлсэн, өрнүүн үйл ажиллагаа явуулж байна.

Өнөөгийн бидний эрх чөлөө, тусгаар тогтнол, Монгол хэмээх бахархал нь хувьсгалт тэмцэл, дайн, тулалдаанд амь насаа алдсан өвөг дээдэс, эрэлхэг баатруудын халуун амь, бүлээн цус, Та бүхний залуу халуун насны цог хиймөр, эх оронч үзэл, ард түмний дэмжлэг, бүтээлч хөдөлмөрийн үр дүн юм.

Зэвсэгт хүчний өнөөгийн болон цаашдын хөгжлийн дүр төрх, бидний хамтдаа бүтээсэн ололт амжилт улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа болж, бүс нутгийн энх амгалан байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмэр оруулж, дэлхий дахинд Монгол Улсын нэр хүндийг улам батгааж үйл явцаар тодорхойлогдох болно.

Та бид өнөөдөр, мянганаар өртөөлсөн Монгол цэргийн нэгэн зууныг үдэж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх дараагийн зууны шинэ хуудсыг хамтдаа нээж байна.

Та бүхэнд болон нийт ард түмэндээ Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын мэндийг дахин хүргэж, ажил албанд тань арвин их амжилт, амьдралд тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн өрөө!

Та бүхнийг Бүх цэргийн их хар сүлд ивээх болтугай.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо" сонин редакцдад бэлтгэв.

***Зар, рекламьг хямд нийтэлнэ.**
***Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.**
***Зохиогчийн үзэл бодол сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.**
***Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.**